



ХҮҮХЭД ЗАЛУУЧУУДЫН ТЕАТРЫН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2024 оны 11 сарын 19 өдөр

Дугаар 1/83


Улаанбаатар хот

Нийгмийн баталгааг хангах хөтөлбөр батлуулах тухай

Монгол улсын Төрийн албаны тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.3, 61 дүгээр зүйл, Соёлын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.6, Соёлын сайдын 2022 оны А/139 дүгээр тушаалын нэгдүгээр хавсралтаар батлагдсан “Хүүхэд, залуучуудын театрын дүрэм”-ийн 4 дэх хэсгийн 4.4.7 дахь заалт, “Байгууллагын хөдөлмөрийн дотоод журам”-ын 4.4.19 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Байгууллагын 2024-2028 онд хэрэгжүүлэх “Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”-ийг нэгдүгээр хавсралтаар баталсугай.
2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг жил бүрийн улсын төсөвт тусгахыг Ерөнхий нягтлан бодогч (Ж.Номин)-д үүрэг болгосугай.
3. Хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнг хагас, бүтэн жилээр тайлагнаж ажиллахыг Хүний нөөцийн төлөвлөлт, сургалт судалгааны мэргэжилтэн (Ц.Усанболороо)-д үүрэг болгосугай.
4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын хэлтсийн дарга (Ю.Батцэнгэл)-д даалгасугай.

ЗАХИРАЛ



Н.АРИУНБОЛД

182402508